# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Агуулга**


1. гэрчилгээ....3

2. Аудитын тайлан ....5

2.1. Оршил ....5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....5

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....6

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин....6

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....7

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....7

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар....8

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн ....8

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ....8
2.8.2. Авлага ....9
2.8.3. Урьдчилгаа ....10
2.8.4. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө ....11
2.8.5 Үндсэн хөрөнгө....12
2.8.6. Өр төлбөр ....13
2.8.7. Засгийн газрын хувь оролцоо ....14
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....14

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....16

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....19

2.12. Шилэн дансны мэдээлэл....20

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ....20

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....20

3. Менежментийн захидал ....21

3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал ....21
3.2 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал....22
3.3 Балансын данстай холбоотой асуудал ....22
3.4 Зардлын данстай холбоотой асуудал....23
3.5 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал....23
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал....24
3.7 Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал ....24
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан....26

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ....26
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ....27
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан....28
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....29
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....30
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....32
5. Хавсралт....33

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....33
5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....37
5.3 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл....43
5.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл. ....49
6.Албан шаардлага....58

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БНСУ | Бүгд найрамдах Солонгос улс |
| ГБХЗХГ | Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар |
| ЗГ | Засгийн газар |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| ПТК | Барилгын техникийн коллеж |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХБХСХТ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв |
| ХНХС | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын |
| ХНХҮТ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХҮГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ХХҮХ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс |
| ХЭДС | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |
| ХЭҮЗ | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.24 № 1442

танай ______________-ны № ______________-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, НББОУС, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно

Аудитын гол асуудал

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан болон аймаг, дүүргүүд дэх дэд сангаас 2013-2017 оны хооронд 9 хөтөлбөрийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгосон зээлийн гэрээний эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн нийт 25,304.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр олгогдсон зээлтэй холбоотой татан буугдсан Анод банкнаас авах 800.0 сая, Капитал банкнаас авах 1,300.0 сая, "Дэлгэр эксперс" ХХК-тай холбоотой 43.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

зэрэг нь санхүүгийн тайлангийн Оршин байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Д.ЗАНДАНБАТ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн санхүүжилтийг хуульд нийцүүлж оновчтой хуваарилах, харьяа байгууллагуудын орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хангуулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, төсвийн гүйцэтгэлийн тайлбар тодруулгыг иж бүрэн бэлтгэж байх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/1007 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны  эрхэм зорилго нь “Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлжээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дараах чиглэлд үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ур чадварын нэмэгдэл;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад шагнал, урамшуулал;
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох;

- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээний шинэчлэлд өөрчлөлт хийгдсэн байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ХНХС-ын 2017 оны А/270 дугаар тушаалаар баталж, ашиглаж байгаа боловч холбогдох стандарт, журмын өөрчлөлтүүдтэй уялдуулж шинэчлэл хийгээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан холбогдох стандарт, хууль журамд нийцүүлэн үнэн зөв бэлтгэгдэхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас ХНХС-ын харьяа төсөвт байгууллага, тусгай сан зэрэг 10 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит , хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байна.

Баталсан төлөвлөгөөний дагуу 8 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тайлант онд бүрэн гүйцэтгэсэн бөгөөд, ХНХЯ, Хөдөлмөр нийгмийн судалгааны институтийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг 2020 он дамжин гүйцэтгэсэн байна. Төлөвлөгөөт бус 4 хяналт шалгалтын хүрээнд 14 байгууллагыг хамруулан шалгасан байна. 2019 онд хэрэгжүүлсэн хяналт, шалгалтаар нийт 3,556.2 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 15.3 сая төгрөгийн зөрчилд төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, 1,397.9 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж 237 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Хэдийгээр төлөвлөсөн хяналт шалгалтыг гүйцэтгэж илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа боловч зээлийн авлага их хэмжээгээр хуримтлагдсан Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сан болон Нийгмийн халамжийн сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Цаашид Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын хүрээнд их хэмжээний хөрөнгө эргэлддэг төсөл, хөтөлбөрүүд, салбарын хөрөнгө оруулалт, тусгай сангууд болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах талаар анхаарч ажиллах нь зүйтэй юм.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,591,803.7 сая төгрөгийн 1 хувь буюу 15,918.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 15,911.7 сая төгрөгөөр тогтоосон нь санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнд өөрчлөлт орсонтой холбоотой болно.

### 2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

#### 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,605.9 сая, эцсийн үлдэгдэл 7,609.2 сая төгрөг болж, 1,996.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 3.4 | 0.9 | (2.5) |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 9,602.5 | 7,332.0 | (2,270.5) |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | - | 276.3 | 276.3 |
| Хадгаламж | - | | - |
| **Дүн** | **9,605.9** | **7,609.2** | **(1,996.7)** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 9,380.0 | 3,370.4 | -6,009.6 |
| Төсөл/ сан | 225.5 | 4,225.3 | 3,999.8 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 0.4 | 13.5 | 13.1 |
| **Дүн** | **9,605.9** | **7,609.2** | **-1,996.7** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Банканд байршиж буй 7,332.0 сая төгрөгийн үлдэгдлийн 7,331.6 сая нь төгрөгийн, 0.4 сая нь гадаад валютаарх үлдэгдэл байна. Үүнээс 3,370.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 4,225.3 сая төгрөг төсөл сангийн, 13.5 сая төгрөг төрийн өмчит байгууллагын үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Архангай, Булган, Өвөрхангай, Увс аймгийн халамжийн дэд сангаас оны эцсийн өдөр төсвийн зарцуулагдаагүй 276.3 сая төгрөгийн үлдэгдлийг Нийгмийн халамжийн төв санд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Нийгмийн халамжийн сан төсвийн зарцуулагдаагүй 1,145.1 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй;
- Кассаар хүлээн авсан 83.3 сая төгрөгийн өөрийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр шууд захиран зарцуулсан. /Үйлдвэрлэл урлалын ПТК 72.7 сая, Дундговь аймгийн МСҮТ 3.0 сая, Орхон аймаг дахь МСҮТ 7.6 сая/;
- Монгол Солонгосын ПТК анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар 9.0 сая төгрөгийн ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч, тайлагнасан;

- Баян-Өлгий аймгийн ХХҮГ байгууллагын туслах үйл ажиллагааны орлогын 6.0 сая төгрөгийн үлдэгдлийг зарцуулснаар тайлагнасан, 35.9 сая төгрөгийн ажил, гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй мөнгөн хөрөнгийн данснаас зардалд шууд бүртгэсэн;

### 2.8.2. Авлага

Авлагын оны эхний үлдэгдэл 146,714.2 сая, эцсийн үлдэгдэл 190,328.1 сая төгрөг болж, 43,613.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл / сая төгрөг /*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 101.1 | 120.3 | 19.2 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 98.5 | 233.4 | 134.9 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 47,718.9 | 98,681.3 | 50,962.3 |
| Зээлийн хүүгийн авлага | - | 56.9 | 56.9 |
| **Бусад авлага** | **5,364.7** | **5,231.3** | **(133.4)** |
| Байгууллагаас авах авлага | 3,779.7 | 3,669.2 | (110.5) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 1,585.0 | 1,562.2 | (22.9) |
| **Зээлийн авлага** | **93,431.0** | **86,004.9** | **(7,426.1)** |
| **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **93,431.0** | **78,004.9** | **(15,426.1)** |
| Хувь хүмүүст олгосон зээл | 34,261.1 | 44,185.0 | 9,923.9 |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 59,169.9 | 33,819.9 | (25,350.0) |
| **Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага** | **-** | **8,000.0** | **8,000.0** |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | - | 8,000.0 | 8,000.0 |
| **Дүн** | **146,714.2** | **190,328.1** | **43,613.9** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 146,623.5 | 190,162.9 | 43,539.4 |
| Төсөл/ сан | 1.9 | 2.4 | 0.5 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 88.8 | 162.7 | 74.0 |
| **Дүн** | **146,714.2** | **190,328.1** | **43,613.9** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Нийт авлагын 51.8 хувийг татаас санхүүжилтийн, 45.2 хувийг зээлийн авлага, 3.0 хувийг бусад авлагын үлдэгдэл эзэлж байна.

Татаас санхүүжилтийн 98,681.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд ХЭДС-ийн 96,656.4 сая, ХХҮЕГ-ын харьяа газруудын нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1,553.7 сая, ХНХЯ-ны 198.3 сая, ГБХЗХГ-ын 156.4 сая, Ахмад настны асрамжийн төвийн 15.2 сая, Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ мэдээллийн төвийн 34.8 сая, 9 МСҮТ-ийн 66.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн авлага бүртгэгдсэн байна.

Зээлийн авлагын 86,004.9 сая төгрөгийн үлдэгдэлд ХЭДС-ийн дотоод болон гадаад эх үүсвэрээс хувь хүмүүс болон аж ахуйн нэгж байгууллагад олгосон зээлийн авлага бүртгэлтэй байна. Зээлийн авлага өмнөх оноос 8.0 хувиар буурсан боловч 27,717.9 сая төгрөгийн олон жил болсон, зээлийн гэрээний эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнд:

- 2013 онд үүссэн “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэг, хүү, алдангийн 18,514.6 сая төгрөг,
- Жижиг зээл хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах гэрээний санхүүжилтийн үлдэгдэл болох Капитал банктай холбоотой зээл, алдангийн 1,565.6 сая , 2015 онд татан буугдсан Анод банктай холбоотой 800.0 сая,
- 2008 онд үүссэн Дэлгэр экспресс ББСБ-тай холбоотой 47.5 сая,

- 2015-2017 онд хэрэгжүүлсэн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2,296.2 сая,
- 2014-2017 онд хэрэгжүүлсэн малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 1,882.7 сая,
- 2017 онд ЗГ болон ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөрийн 1,650.4 сая,
- 2017 онд хэрэгжүүлсэн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөтөлбөрийн 129.8 сая,
- 2017 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 681.8 сая,
- Бусад хөтөлбөрийн 149.4 сая төгрөгийн авлага байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан болон аймаг, дүүргүүд дэх дэд сангаас 2013-2017 оны хооронд 9 хөтөлбөрийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгосон зээлийн гэрээний эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн нийт 25,304.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;*
- *Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр олгогдсон зээлтэй холбоотой татан буугдсан Анод банкнаас авах 800.0 сая, Капитал банкнаас авах 1,300.0 сая, “Дэлгэр эксперс” ХХК-тай холбоотой 43.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;*
- *Насжилт өндөртэй олон жил болсон 72.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй /Дундговь аймгийн МСҮТ 11.6 сая, Олон улсын Найрамдал цогцолбор 30.3 сая, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв 25.6 сая, Орхон аймгийн ХХҮГ 5.4 сая/;*
- *Авлагын 51.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /БНСУ дахь ХНХҮТ 45.1 сая, Төв аймгийн МСҮТ 6.4 сая/;*
- *Төсвийг зохистой удирдаагүйгээс санхүүгийн тайланд шинээр 242.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн /Булган аймгийн ХХҮГ 5.2 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 8.1 сая, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ 10.2 сая, Баянхонгор аймгийн ПТК 4.9 сая, Говьсүмбэр аймгийн ПТК 48.9 сая, Дорнод аймгийн МСҮТ 6.5 сая, Өмнөговь аймгийн ПТК 2.0 сая, Үйлдвэрлэл урлалын ПТК 2.5 сая, Говьсүмбэр аймгийн ПТК 10.0 сая, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв 143.9 сая/*

### 2.8.3. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 343.7 сая, эцсийн үлдэгдэл 522.6 төгрөг болж, 178.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 3 Урьдчилгаа данс / сая төгрөг /*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 305.1 | 493.9 | 188.8 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 23.7 | - | (23.7) |
| Цалингийн урьдчилгаа | 14.8 | 28.7 | 13.9 |
| Томилолтын урьдчилгаа | 0.1 | - | (0.1) |
| **Дүн** | **343.7** | **522.6** | **178.9** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 304.5 | 494.9 | 190.4 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 39.2 | 27.7 | -11.5 |
| **Дүн** | **343.7** | **522.6** | **178.9** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансанд 2019 онд үүссэн 9 байгууллагад хамаарах 522.6 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Өмнөх оноос өссөн шалтгаан нь ГБХЗХГ нь “Хүүхэд, гэр

бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гэр бүл, эцэг эхчүүдэд зориулсан бүрэн хэмжээний уран сайхны кино хийх" зөвлөх үйлчилгээний төлбөрт 266.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг оны эцэст шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 2.8.4. Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө

Бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 32,705.6 сая, эцсийн үлдэгдэл 50,688.0 сая төгрөг болж, 17,982.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл / сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **3,667.1** | **3,884.0** | 216.9 |
| Тусгай зориулалттай материал | 3,431.8 | 3,352.3 | (79.6) |
| Эм боох материал | 235.3 | 531.7 | 296.4 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 18.9 | - | (18.9) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 131.5 | 113.7 | (17.9) |
| **Хангамжийн материал** | **10,564.0** | **10,474.5** | **(89.5)** |
| Бичиг хэргийн материал | 416.6 | 420.0 | 3.4 |
| Аж ахуйн материал | 5,250.5 | 5,163.6 | (86.9) |
| Сэлбэг хэрэгсэл | 526.8 | 516.5 | (10.3) |
| Түлш, шатах тослох материал | 60.8 | 94.7 | 33.9 |
| Барилгын засварын материал | 704.8 | 651.3 | (53.5) |
| Хүнсний материал | 605.2 | 575.3 | (29.9) |
| Бусад хангамжийн материал | 2,999.3 | 3,053.2 | 53.9 |
| Биологийн хөрөнгө | - | - | - |
| Мал амьтад | 448.4 | 474.0 | 25.6 |
| **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **17,875.8** | **35,741.9** | **17,866.1** |
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 17,875.8 | 35,741.9 | 17,866.1 |
| **Дүн** | **32,705.6** | **50,688.0** | **17,982.4** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр*** | | | |
| Төсөвт байгууллага | 32,021.6 | 49,952.2 | 17,930.6 |
| Төсөл/ сан | 9.9 | 10.0 | 0.1 |
| Төрийн сан | | | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 674.1 | 725.8 | 51.7 |
| **Дүн** | **32,705.6** | **50,688.0** | **17,982.4** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн 35,741.8 сая төгрөг бүртгэлтэй байна. Үүнээс 7,241.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг улсын комиссын актаар хүлээн авсан боловч ашиглагч байгууллагад шилжүүлж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлээгүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Худалдан авсан 50.1 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар бүртгэсэн. /Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ПТК 6.6 сая, Баян-Өлгий аймгийн ХХҮГ 13.0 сая, Орхон аймгийн ХХҮГ 30.5 сая/;
- Бараа материалын 81.1 сая төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, баталгаажуулаагүй /ГБХЗХГ 64.3 сая, Багануур дүүргийн ХХҮХ 16.8 сая/.

### 2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 384,013.6 сая, эцсийн үлдэгдэл 383,163.8 сая төгрөг болж, 849.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №5 Үндсэн хөрөнгө /сая төгрөг /*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **346,883.5** | **344,579.9** | **(2,303.6)** |
| Барилга, байгууламж, орон сууц | 230,554.9 | 232,560.7 | 2,005.8 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 10,314.7 | 11,145.3 | 830.6 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 68,440.3 | 71,030.6 | 2,590.2 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,187.2 | 15,433.5 | (753.6) |
| Зам, гүүрний байгууламж | 304.7 | 304.7 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 4,258.8 | 4,452.5 | 193.7 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 14,266.3 | 7,060.3 | (7,206.0) |
| Ном | 2,556.7 | 2,592.3 | 35.6 |
| **Биет бус хөрөнгө** | **37,130.1** | **38,583.9** | **1,453.8** |
| Программ хангамж | 5,840.6 | 5,994.2 | 153.6 |
| Бусад биет бус хөрөнгө | 31,289.5 | 32,589.7 | 1,300.2 |
| **Дүн** | **384,013.6** | **383,163.8** | **(849.8)** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 365,628.9 | 364,965.7 | (663.14) |
| Төсөл/ сан | 1,252.3 | 986.3 | (266.04) |
| Төрийн сан | | | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 17,132.4 | 17,211.8 | 79.37 |
| **Дүн** | **384,013.6** | **383,163.8** | **(849.8)** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэсэн 1,370.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 3,079.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,359.4 сая, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 5,088.7 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 1,072.1 сая төгрөг зэрэг нийт 14,970.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бол балансаас баланст шилжүүлсэн 11,918.9 сая, акталсан 2,518.5 сая, дахин үнэлгээний хорогдуулга 1,382.7 сая төгрөг зэрэг нийт 15,820.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ГБХЗХГ 116.9 сая төгрөгийн программ хангамжийг хөрөнгийн орлогоор бүртгээгүй;*
- *Биетээр оршин байхгүй хөрөнгийг үлдэгдлээр тайлагнасан: / Говьсүмбэр аймгийн ПТК 74.5 сая, ХХҮЕГ 28.7 сая/*
- *Биет бус хөрөнгө дансанд хөрөнгө буруу ангилж бүртгэсэн, цаашид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлагагүй болсон, ашиглагдаагүй 177.3 сая программ хангамж бүртгэлтэй /ХНХЯ 33.6, ХХҮЕГ 123.9 сая, Хэнтий аймгийн МСҮТ 18.0 сая , Баянхонгор аймгийн ПТК 1.8 сая/;*
- *ГБХЗХГ Үндсэн хөрөнгө дансанд буруу ангилж бүртгэсэн 75.9 сая төгрөг*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь Эдийн засаг, техник хамтын ажиллагааны тухай МУ-ын ЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын 2016 оны хэлэлцээрийн дагуу " Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих " төслийн хүрээнд Эмчилгээ тоног төхөөрөмжийн 292 зүйл, доторх тавилгын 24 зүйл, гал тогооны тоног төхөөрөмжийн 91 зүйл, эмчилгээ сэргээн заслын тоног төхөөрөмжийн гарын авлага зэрэг нийт 16.9 сая юанийн үнийн дүнтэй хөрөнгийг 2019 оны 5 сард хүлээн авсан боловч орлого авч санхүүгийн тайланд тусгаагүй байна. Хөрөнгө хүлээн авсан өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцоход **6,514.7** сая төгрөгийн үнийн дүнтэй хөрөнгө хүлээн авсан байна.*

### 2.8.6. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 31,236.3 сая, эцсийн үлдэгдэл 36,595.1 сая төгрөг болж, 5,358.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 6 Нийт өр төлбөр / сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
|---|---|---|---|
| ***<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>*** | **23,183.3** | **28,371.8** | **5,188.5** |
| Богино хугацаат зээлийн өглөг | 10.3 | 7.7 | (2.5) |
| Өглөг | 4,390.4 | 5,899.2 | 1,508.8 |
| Бусад өглөг | 3,690.5 | 5,265.3 | 1,574.8 |
| Урьдчилж орсон орлого | 18,782.6 | 22,464.8 | 3,682.2 |
| ***<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>*** | **8,053.0** | **8,223.3** | **170.3** |
| **Урт хугацаат зээл** | **8,053.0** | **8,223.3** | **170.3** |
| **Төгрөг** | 9.0 | 8,223.3 | 8,214.3 |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | - | 8,214.9 | 8,214.9 |
| Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 9.0 | 8.4 | (0.7) |
| **Гадаад валют** | **8,044.0** | **-** | **(8,044.0)** |
| Олон улсын санхүүгийн байгууллагаас | 8,044.0 | - | (8,044.0) |
| **Дүн** | **31,236.3** | **36,595.1** | **5,358.7** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 30,382.5 | 35,936.4 | 5,553.9 |
| Төсөл, сан | 206.4 | 96.5 | (109.9) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 647.5 | 562.1 | (85.4) |
| **Дүн** | **31,236.3** | **36,595.1** | **5,358.7** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдлийг төрлөөр авч үзвэл ажиллагчидтай холбогдсон өглөг 0.6 хувь, бараа үйлчилгээний зардлын өглөг 1.5 хувь, байгууллагад төлөх өглөг 1.1 хувь, хувь хүмүүст төлөх өглөг 17.5 хувь, урьдчилж орсон орлого 79.2 хувийг тус тус эзэлж байна.

Хувь хүнд төлөх өглөгийн үлдэгдэл оны эцэст 4,946.1 сая төгрөг болж өмнөх оноос 1,766.2 сая төгрөгөөр өссөн нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тайланд МСҮТ суралцагчдын тэтгэмж, хувьсах зардлын 2019 оны 12-р сарын олгогдоогүй үлдэгдэл 2,799.2 сая, 8 аймаг, 9 дүүргийн Халамжийн сангийн 14 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн олгогдоогүй 2,119.8 сая төгрөг зэрэг өр төлбөр бүртгэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Урьдчилж орсон орлогын дансны 22,464.8 сая төгрөгийн үлдэгдэлд ХЭДС-ийн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2020 оны зөвшөөрлийн урьдчилгааны 22,222.5 сая, барьцаа дэнчингийн дансны 18.0 сая, 6 байгууллагын ажил, үйлчилгээний урьдчилгаа орлогын 224.3 сая төгрөгийн орлого тус тус бүртгэгдсэн байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2019 онд Сангийн яам, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын хооронд байгуулсан Дэлхийн банкны төслөөс дамжуулан зээлдүүлэх гуравласан гэрээний дагуу "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл"-ийн санхүүжилт 8,000.0 сая төгрөгийн өр, ханшийн зөрүү 214.9 сая төгрөг нийт 8,214.9 сая төгрөгийн өр, Барилгын ПТК-ийн 8.4 сая төгрөгийн өрийн үлдэгдэл бүртгэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт*

- *Орхон аймаг дахь МСҮТ 2.0 сая төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, өмнөх оноос шилжин ирсэн өр төлбөрийг барагдуулаагүй;*
- *ГБХЗХГ өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй 120.1 сая төгрөгийн өр төлбөрийг тайлант онд гүйцэтгэж, тайлант оны зардалд тусгасан.*

### 2.8.7. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 461,654.0 сая, эцсийн үлдэгдэл 501,744.3 сая төгрөг болж, 40,090.3 төгрөгөөр өссөн байна

*Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо / сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 116,176.9 | 117,562.5 | 1,385.5 |
| **Хуримтлагдсан үр дүн** | **227,308.8** | **266,337.3** | **39,028.4** |
| Өмнөх үеийн үр дүн | 217,344.9 | 233,988.0 | 16,643.0 |
| Тайлант үеийн үр дүн | 9,963.9 | 32,349.3 | 22,385.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 118,168.2 | 117,844.6 | (323.7) |
| **Дүн** | **461,654.0** | **501,744.3** | **40,090.3** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 445,273.0 | 481,930.3 | 36,657.30 |
| Төсөл, сан | 1,067.7 | 4,950.2 | 3,882.5 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 15,313.4 | 14,863.9 | (449.5) |
| **Дүн** | **461,654.0** | **501,744.3** | **40,090.3** |

*Эх сурвалж: ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал данс оны эхэнд 116,176.9 сая төгрөг байснаас оны эцэст 117,562.5 сая төгрөг болж 1,385.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Ховд аймгийн Хөгжил ПТК 1,043.5 сая, Ахмад настны үндэсний төвийн 342.0 сая төгрөгөөр байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй газрыг үнэлж хөрөнгийн орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 10 байгууллага өмнөх үеийн үр дүнг 1,622.3 сая төгрөгөөр бууруулах, 22 байгууллага 8,301.5 сая төгрөгийн нэмэгдүүлэх залруулга хийж хуримтлагдсан үр дүнг 233,988.0 сая төгрөгөөр дахин илэрхийлсэн бөгөөд тайлант жилийн үр дүн 32,349.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж оны эцэст 266,337.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс оны эхэнд 118,168.2 сая төгрөг, жилийн эцэст 117,844.6 сая төгрөг болж, 323.7 сая төгрөгөөр буурсан нь акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хасаж бүртгэсэн байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2019 оны төсвийн тухай хуулиар ХХҮЕГ 580.0 сая төгрөгийн төлбөр, хураамжийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсаныг бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 1,660,401.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, 1,559,176.3 сая төгрөгийг улсын төсвөөс,

631.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 100,594.1 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,534,291.4 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 580.9 сая нийт 1,534,872.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төлөвлөснөөс 24,935.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 56,592.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 14,786.2 сая төгрөгөөр давсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого 25,382.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 19,258.5 сая төгрөгөөр тасарсан нь МСҮТ-д суралцагчдын тоо буурсан, төлөвлөгөөг хэт өндөр баталж өгснөөс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,579,790.7 сая төгрөг буюу 95.1 хувийн гүйцэтгэлтэй гарж 80,610.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Бараа ажил, үйлчилгээний зардал салбарын хэмжээнд гүйцэтгэлээр 5,801.7 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан;
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 19,705.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь ядуу өрхийн тэтгэмжийг зохицуулсан журам нь батлагдаагүйгээс 9,223.7 сая төсөвлөсөн зардал зарцуулагдаагүй, бусад тэтгэмжийн зардал гүйцэтгэлээр 10,482.2 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан;
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 50,201.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь ХЭДС 27,786.0 сая, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан МСҮТ-ийн суралцагсдын тэтгэлгийн зардал болон 22,415.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалсан;
- ХЭДС-ийн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хуваарилах суралцагчдын тэтгэлэг 22,415.7 сая, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ зардлаас 150.8 сая, ажилд зуучлах үйлчилгээ зардлаас 393.8 сая, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрөөс 244.6 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 1,659.4 сая, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 672.7 сая, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 424.2 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 477.3 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрөөс 204.1 сая төгрөг зэрэг хөтөлбөрийн зардлыг гүйцэтгэлээр дутуу санхүүжүүлсэн;
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зардлын гүйцэтгэл дутуу байгаа нь түр сургалтын болон МСҮТ-ийн хэв шинжийг агуулаагүй сургалтын төвд суралцагчдад тэтгэлэг олгоогүй, суралцагчдын ирцийн гүйцэтгэлээр тэтгэлгийг олгосон, 2018-2019 оны хичээлийн жилд элсэгчдийн тоо төлөвлөснөөс буурсан зэргээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 37 төсөл, арга хэмжээнд 33,895.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 29,456.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Хөрөнгийн зардал 4,439.1 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь зардлын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаагүй, 3 арга хэмжээ хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Аймаг, нийслэлд эрх шилжсэн 26 ажлын санхүүжилтэд гүйцэтгэлээр 17,918.8 сая, эрх шилжээгүй 11 ажлын гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 7,291.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 4,079.9 сая төгрөгийг суутган барьцаа дансанд, 166.6 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 2,950.0 сая төгрөгийн Ахмадын өргөөний барилга, Ахмад залуучуудын хөгжлийн төвийн барилга, Залуучуудын хөгжлийн төвийн барилга зэрэг 3 төсөл арга хэмжээнүүд зураг төсөвт өөрчлөлт орсон, барилга байгууламж барих газрын зөвшөөрөл гараагүйгээс худалдан авах ажиллагаа оны эцэст зохион байгуулагдсанаас шалтгаалан хийгдээгүй, 3,380.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь тендер оройтож зарлагдсан, гүйцэтгэгчийн материал тээвэрлэлтээс шалтгаалан гэрээ байгуулсан боловч гүйцэтгэл гараагүйгээс шалтгаалан дуусаагүй, он дамжин хийгдэхээр болсон байна. Гэрээ байгуулагдсан боловч гүйцэтгэл гараагүй ажлын 3,380.6 сая, дуусаагүй ажлын 699.3 сая төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцааны дансанд байршуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжийн орлогоос 12,493.1 сая, Засгийн газрын нөөц сан болон түүнтэй адилтгах бусад шатны төсвийн захирагчаас авсан хөрөнгө 6,287.8 сая, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө 1,156.6 сая, төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлогоос 1,393.7 сая, нийт 21,331.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал үйл ажиллагаанд 11,170.2 сая, хөрөнгийн зардалд 97.9 сая, эргэж төлөгдөх зээлд 8,000.0 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 2,063.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Аудитаар зардлын данс, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дараах материаллаг алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:*

- *ГБХЗХГ төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119.5 сая төгрөгийн, ХХҮЕГ давсан орлогоос ТӨБЗ-ын зөвшөөрөл гараагүй байхад урьдчилан хөрөнгө бэлтгэсэн 76.8 сая төгрөг.*
- *Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан болон зориулалт бусаар зарцуулсан 77.7 сая төгрөг /ХНХЯ 29.9 сая,Булган аймгийн ХХҮГ 1.9 сая, СХД ХХҮХ 4.1 сая, Төв аймгийн ХХҮГ 1.7 сая сая, Говь-Алтай аймгийн МСҮТ 4.1 сая, Барилгын ПТК 8.5 сая, Монгол-Солонгосын ПТК 24.5 сая, ХБХСХТ 3.0 /;*
- *МСҮТ, ПТК-ууд дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг мөрдөөгүйгээс 35.0 сая төгрөгийн зардлыг хэтрүүлэн болон бусад зардалд зориулалт бусаар зарцуулсан. / Архангай аймгийн МСҮТ 12.0 , Барилгын ПТК 12.6 сая, Дорноговь аймаг дахь МСҮТ 3.4 сая, , Төв аймгийн Заамар суман дахь МСҮТ 2.3 сая, Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь МСҮТ 4.7 сая, / ;*
- *Хөрөнгө бараа материалын худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй. /БЗД ХХҮХ 95.0 сая, Говь-Алтай аймгийн МСҮТ 25.9 сая, Дархан-Уул аймаг дахь Дархан-Өргөө ПТК 69.8 сая,*
- *БНСУ дахь ХНХҮТ нь ажилчдад олгох байрны түрээсийн зардлыг дотоод журамд заасан хэмжээнээс илүү тооцож, нийт 22.4 сая төгрөгийг илүү олгосон;*
- *Говь-Алтай аймгийн ХХҮГ төрийн захиргааны дэс түшмэлийн сул орон тоонд төрийн албаны шалгалт өгөөгүй 2 иргэнийг томилж, 18.2 сая төгрөгийн цалин олгосон;*
- *Дархан-Уул аймгийн ХХҮГ үндсэн үйл ажиллагааны зардлаас бүтэц орон тоонд батлагдаагүй малчин, сахиулын цалинд 9.3 сая төгрөг зарцуулсан.*
- *Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй төрийн үйлчилгээний ажилтнуудын цалин, НДШ-ийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөн, батлуулж, санхүүжүүлсэн. /ХНХЯ-152.5 сая, ХХҮЕГ -93.5 сая төгрөг/*

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, 83 төсвийн байгууллага, 1 төрийн өмчит аж ахуйн нэгж, 3 тусгай сан, 61 дэд сан, 12 хөрөнгө оруулалт, их засвар, хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналт, Аймаг, дүүрэг дэх ЖДҮДТ-ийн нийт 161 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 148 байгууллага аудитад хамрагдсан, 8 итгэл үзүүлсэн, 5 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үүнд: БЗД, Говь-Алтай, Завхан аймгийн ЖДҮДТ 2019 онд үйл ажиллагаа явуулаагүйгээс, Булган аймгийн МСҮТ, ХАА-н МСҮТ-үүд төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй зэрэг шалтгаанаас аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 11 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 137 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 120, “Хязгаарлалттай” 16, “Сөрөг” 1 дүгнэлт өгсөн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 126,043.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 81,575.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1,295.5 сая төгрөгийн зөрчилд 69 төлбөрийн акт тогтоож, 31,014.4 сая төгрөгийн зөрчилд 79 албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 12,158.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 267 зөвлөмж өглөө.

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга*

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 4,079.6 сая төгрөгөөр бараа материалын үлдэгдлийг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд орлогыг 8,044.0 сая төгрөгөөр, зардлыг 585.0 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд засгийн газрын санг 342.0 сая төгрөгөөр дутуу, дахин үнэлгээний нэмэгдлийг 781.0 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 17,918.8 сая төгрөгөөр хөрөнгийн санхүүжилтийн орлогыг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн тайланд 79.6 сая төгрөгийн давхардсан орлого болон зардлын ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу хийж, тайлагнасан алдаануудыг санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа.

*Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага*

1. Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн төлбөрт ХНХС-ын эрхлэх асуудлын 3 байгууллагын төсвөөс нийт 63.1 сая төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй байна. Үүнд: ГХЗХГ 2 ажилтны 17.5 сая, ХХҮЕГ 1 ажилтны 28.9 сая, Сэлэнгэ аймгийн МСҮТ 1 ажилтны 16.7 сая төгрөг.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 -д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага

өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2. Булган аймаг МСҮТ, ХАА-н МСҮТ зэрэг байгууллагууд нь Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг хүргүүлээгүйгээс аудит хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх

Төсвийн ерөнхийлөн захирагчид 6,976.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмжийг өгч, менежментийн захидалд дурдсан болно.

*Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар*

Аудитаар нийт 414.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 24.9 сая төгрөгийн алдааг залруулж, 170.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 218.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өглөө.

*Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар*

Харьяа байгууллагуудын нийт 95 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 10 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 72, Хязгаарлалттай 5 / Баянзүрх дүүргийн ХХҮХ, БНСУ ХНХҮТ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Монгол Солонгосын ПТК, Үйлдвэрлэл урлалын ПТК / дүгнэлт өгч, 5 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна. Үүнд: Баянзүрх дүүрэг, Говь-Алтай, Завхан аймгийн ЖДҮДТ-үүд нь 2019 онд үйл ажиллагаа явуулаагүйгээс, Булган аймаг дахь МСҮТ, ХАА-н МСҮТ зэрэг байгууллагууд төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй зэргээс шалтгаалж аудит хийгдээгүй байна.

Аудитаар нийт 39,044.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 28,637.4 сая төгрөгийн алдааг залруулж, 89.4 сая төгрөгийн зөрчилд 52 төлбөрийн акт тогтоож, 8,883.1 сая төгрөгийн зөрчилд 56 албан шаардлага, алдаа, зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 1,434.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 175 зөвлөмж өгсөн байна.

*Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар*

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын санхүүгийн тайланд аудит хийж, Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 42.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 30.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

*Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар*

Харьяа 3 тусгай сангийн санхүүгийн тайланд аудит хийж Нийгмийн халамжийн сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн санхүүгийн тайланд Зөрчилгүй,

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.

Нийгмийн халамжийн санд нэгтгэгдэж байгаа 1 халамжийн сангийн тайланд МУЕА-ын тушаалаар итгэл үзүүлж, Зөрчилгүй 29 дүгнэлт өгсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нэгтгэгдэж байгаа 4 дэд санд МУЕА-ын тушаалаар итгэл үзүүлж, 1 сан түүвэрт хамрагдаж, 28 дэд сангийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргаснаас Зөрчилгүй 17, Хязгаарлалттай 10 / Багануур, Баянгол, Багахангай, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх, Чингэлтэй дүүрэг, Хан-Уул дүүрэг, Нийслэлийн хөдөлмөрийн газар, Говь-Алтай аймгийн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих дэд сан/, Сөрөг 1 /Баянзүрх дүүргийн ХЭДС /санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 47,673.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 21,083.0 сая төгрөгийн алдааг залруулж, 1,198.0 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 21,867.6 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, алдаа, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 3,524.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 75 зөвлөмж өгсөн байна.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар дахин авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

1. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийг төсвийн хуваарийн дагуу сар бүр Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж, 2019 онд нийт 83,193.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч, ЭМДЕГ-тай хагас болон бүтэн жилээр тооцоо нийлж, үр дүнг хянаж авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. ЭМДЕГ-ын 2019 оны жилийн санхүүгийн тайланд өссөн дүнгээр 26,501.2 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн;

2. Засгийн Газрын 2016 оны 3 дугаар тогтоолоор (2018 оны 110 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон) ХНХЯ-ны орон тооны хязгаарыг 119, 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр тогтоолоор ХХҮЕГ-ын бүтэц орон тоог 70 байхаар тус тус тогтоосон боловч тус бүтэц орон тооны хязгаарт багтаагүй жолооч, харуул, нярав, нягтлан бодогч зэрэг төрийн үйлчилгээний орон тооны ажилтнуудын цалинг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөж, батлуулсан;

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэгдсэн 86,004,9 сая төгрөгийн зээлийн авлагын 32.2 хувь нь зээлийн гэрээний эргэн төлөлтийн хугацаа хэтэрч төлөгдөөгүйгээс олон жилийн насжилттай авлага үүссэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс ХЭДС-ийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлж, зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж, Сангийн хөрөнгийг бүрэн хэмжээгээр эргэлтэд оруулж, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай;

4.БНХАУ-ын ЗГ, Монгол Улсын ЗГ-ын хэлэлцээрийн дагуу тус улсын Худалдааны яамны Олон улсын эдийн засаг хамтын ажиллагааны товчоо болон Монгол улсын Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам буцалтгүй тусламжаар баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн төслийг хэрэгжүүлэх 181.6 сая юанийн үнийн дүнтэй гэрээг 2016 оны 06 сарын 13-ны өдөр байгуулсан байна. Төслийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авах, нягтлан бодох бүртгэлд тусгах үйл явцад хяналт тавьж анхаарал хандуулах нь зүйтэй байна.

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байгууллагын болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

ХНХЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас харьяа байгууллагуудын 195 дансны шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулалтад хяналт тавьж ажиллаж байна. Тус газраас гаргасан 2019 оны нэгтгэсэн тайлангаас үзэхэд 5 данс 32-78 хувь, 190 данс 83-100 хувь буюу дунджаар 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Салбарын хэмжээнд мэдээлсэн мэдээллийн 82 хувийг хугацаанд нь, 18 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 1,630.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна. Нийт 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна .

### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, Санхүүгийн тайлангийн аудитын журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 44,468.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 15,911.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс  их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлтийг өгч байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим чиглэгдсэн.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*3.1.1 Илрүүлэлт:*

ХНХС-ын 2019 оны А/181, А/186 дугаар тушаалаар Нийслэл, дүүргийн ГБХЗХГ-ын хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах 2,000.0 сая төгрөгийн төсвийг төсвийн шууд захирагч болох ГБХЗХГ-ын төсөвт тусган баталж, төсвийн шууд захирагч нарын нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжилтийг олгосон боловч, зардлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авч хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 4.1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*3.1.2 Эрсдэл:*

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх.

*3.1.3 Өгсөн зөвлөмж:*

Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг хуульд нийцүүлж, оновчтой хуваарилах, нэмэлтээр олгосон төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.

*3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.2 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал**

*3.2.1 Илрүүлэлт:*
ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний 18 байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө нийт 125.4 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т " хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заасантай нийцэхгүй байна.

*3.2.2 Эрсдэл:*
Орлогын төлөвлөгөө тасрах, санхүүжилтийн эх үүсвэр дутагдсанаас гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх.

*3.2.3 Өгсөн зөвлөмж:*
Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй төлөвлөх, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулж ажиллах талаар хяналт тавьж ажиллах.

*3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.3 Балансын данстай холбоотой асуудал**

*3.3.1 Илрүүлэлт:*

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2,395.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2 төсөл арга хэмжээг улсын комисс ажиллаж барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан боловч захиалагчийн зүгээс ашиглагч байгууллагын эзэмшилд шилжүүлээгүй, данс бүртгэлээс хасаагүй байна. Үүнд: Гэр бүл, хүүхэд, ахмадын соёл, амралтын цогцолборын барилга /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг/ 1,009.3 сая, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын иргэдэд үйлчлэх төвийн барилга /Хэнтий аймаг, Хэрлэн сум/ 1,385.7 сая төгрөг;
- Хөрөнгө оруулалтын тайланд 2015-2016 оны хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаж, улсын комисс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 2017/10 дугаар дүгнэлтээр барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан 4,846.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Хараагүй иргэдийн 90 айлын орон сууцын барилгын ажлыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй, данс бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2-т " батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгжээс хөрөнгө оруулалт санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

*3.3.2 Эрсдэл:*
Хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг бүртгэхгүй байх, санхүүгийн тайланд хөрөнгийн ангилал зөрүүтэй илэрхийлэгдэх, ашиглалтад байгаа барилга, байгууламжид элэгдлийн зардал байгуулагдахгүй байх.

*3.3.3 Өгсөн зөвлөмж:*
Ашиглалтад бүрэн хүлээн авсан дээрх барилга байгууламжийн холбогдох баримт материалыг бүрдүүлж, ТӨБЗГ-т хандан шийдвэр гаргуулж, ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгүүлэх арга хэмжээ авах.

*3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.4 Зардлын данстай холбоотой асуудал**

*3.4.1 Илрүүлэлт:*
Хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлаас ХНХЯ-ны аппаратын ажилтнуудын Хэнтий, Дорнод, Орхон, Дархан-Уул, Өвөрхангай аймагт ажиллах 4 удаагийн албан томилолтын урьдчилгааг олгосон боловч ажилтан, албан хаагчдын албан томилолтоор ажиллах ажлын удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг холбогдох баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д ".Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заасантай нийцэхгүй байна.

*3.4.2 Эрсдэл:*
Техник хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлд тусгагдах.

*3.4.3 Өгсөн зөвлөмж:*
Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, дотоод албан томилолтын урьдчилгаа тооцоог гүйцэтгэсэн ажлын удирдамж, тайланг хүлээн авч хянаж зардлыг гүйцэтгэлээр нь хянаж баримтжуулж байх.

*3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.5 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал**

*3.5.1 Илрүүлэлт:*

- ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуульд заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн түүний танилцуулга тайлбар, тодруулгын хамт ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/;54.5.3-д “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал, толилуулга тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- ТЕЗ нь төсвийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн төсөвтэй сар бүр зохицуулалт хийсэн боловч хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн зорилттой харьцуулж тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.6-д " Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана" заасантай нийцэхгүй байна.

*3.5.2 Эрсдэл:*
Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв тайлагнаагүй байх.

*3.5.3 Өгсөн зөвлөмж:*
Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагын дагуу иж бүрэн бэлтгэн тайлагнаж, Төрийн аудитын байгууллага, Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж байх.

*3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал**

*3.6.1 Илрүүлэлт:*
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох стандарт, хууль, журам, зааврын шинэчлэлийг тусгаж салбарын хэмжээнд мөрдөж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д " Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

*3.6.2 Эрсдэл:*
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

*3.6.3 Өгсөн зөвлөмж:*
Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн болон харьяа байгууллагуудын бүртгэлийн үйл ажиллагаатай уялдсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, салбарын хэмжээнд мөрдөх.

*3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.7 Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал**

*3.7.1 Илрүүлэлт:*
ХНХЯ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дарга, дэд дарга нарын хотын доторх албан ажлын хэрэгцээнд 2500 м3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжаас дээш шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэж байна. Үүнд: / ГБХЗХГ, ХХҮЕГ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Баянзүрх дүүргийн ХХҮХ /
Энэ нь суудлын автомашин ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" тогтоолын хавсралтаар баталсан Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалттай тус тус нийцэхгүй байна.

*3.7.2 Эрсдэл:*
Шатахууныг батлагдсан нормоос илүү зарцуулах, холбогдох хууль, тогтоомж, заавар, журам зөрчих;

*3.7.3 Өгсөн зөвлөмж:*

Өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын албан ажлын автомашины хэрэглээний талаар нэгдсэн байдлаар арга хэмжээ авч ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолтой нийцүүлэх.

*3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 189,369,477.6 | 249,147,935.5 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 9,605,928.2 | 7,609,223.5 |
| 33 | АВЛАГА | 146,714,239.9 | 190,328,117.7 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 343,734.5 | 522,572.8 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 14,829,825.0 | 14,946,170.6 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 17,875,750.0 | 35,741,850.9 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 303,520,911.1 | 289,191,463.3 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 303,520,911.1 | 289,191,463.3 |
| 39200 | Биет хөрөнгө | 268,774,315.8 | 253,867,715.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 34,746,595.3 | 35,323,747.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **492,890,388.8** | **538,339,398.8** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 31,236,350.0 | 36,595,084.0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 23,183,306.0 | 28,371,772.8 |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 10,250.9 | 7,715.2 |
| 41300 | Өглөг | 4,390,447.3 | 5,899,244.6 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 18,782,607.8 | 22,464,813.1 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 8,053,044.0 | 8,223,311.1 |
| 42200 | Урт хугацаат зээл | 8,053,044.0 | 8,223,311.1 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 461,654,038.8 | 501,744,314.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 461,654,038.8 | 501,744,314.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 116,176,944.8 | 117,562,460.8 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 227,308,849.3 | 266,337,290.7 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 118,168,244.7 | 117,844,563.4 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **492,890,388.8** | **538,339,398.8** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,246,869,692.6** | **1,623,500,841.6** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 67,119,771.7 | 94,312,287.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 67,023,810.8 | 94,312,287.6 |
| 122 | Тусламжийн орлого | 95,960.9 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,179,749,920.9 | 1,529,188,554.0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,215,734,204.0** | **1,574,601,435.4** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,203,463,802.1 | 1,574,601,435.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 121,128,708.2 | 136,835,630.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 49,887,831.3 | 61,412,137.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,941,814.0 | 7,676,014.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,668,487.5 | 12,009,774.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,702,359.7 | 4,335,215.5 |
| 2105 | Нормативын зардал | 6,432,398.4 | 6,963,624.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,409,656.4 | 1,875,817.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 751,945.5 | 930,250.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,759,524.8 | 12,415,620.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,574,690.7 | 29,217,176.3 |
| 211 | ХҮҮ | - | 182.5 |
| 212 | ТАТААС | 609,817,672.0 | 605,492,793.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 472,517,421.9 | 832,272,828.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 12,270,402.0 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 31,135,488.6 | 48,899,406.2 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 921,187.0 | 14,969.3 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 22,092,742.9 | 16,565,050.6 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **9,963,932.6** | **32,349,324.9** |

### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,298,316,892.3** | **1,692,916,535.8** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 113,723,445.1 | 129,874,600.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 113,627,484.3 | 129,874,600.5 |
| 122 | Тусламжийн орлого | 95,960.9 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,184,593,447.2 | 1,563,041,935.3 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,254,880,872.8** | **1,678,079,019.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,254,880,872.8 | 1,678,079,019.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 106,872,890.7 | 120,813,180.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 48,833,503.3 | 61,132,401.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,875,851.4 | 7,624,854.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,631,889.3 | 11,942,212.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,724,193.2 | 3,055,345.2 |
| 2105 | Нормативын зардал | 6,698,085.4 | 7,884,390.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,607,444.6 | 2,203,433.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 738,343.7 | 929,954.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,694,855.2 | 14,092,244.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,068,724.6 | 11,948,344.9 |
| 212 | ТАТААС | 609,817,672.0 | 605,492,793.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 538,190,310.1 | 951,773,045.7 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **43,436,019.5** | **14,837,516.5** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **6,975.0** | **-** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **24,167,482.9** | **8,828,548.4** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 24,167,482.9 | 8,828,548.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 24,167,482.9 | 8,828,548.4 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-24,160,507.9** | **-8,828,548.4** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-14,952,969.8** | **-8,005,672.7** |
| 14 | Бусад эх үүсвэр | 963,410.1 | 789.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 15,900,000.0 | 8,000,000.0 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 16,379.9 | 6,461.9 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **4,322,541.8** | **-1,996,704.7** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 5,283,386.4 | 9,605,928.2 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,605,928.2 | 7,609,223.5 |

### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,806,846.4** | **327,806,846.4** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 10,325,501.9 | 10,325,501.9 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 338,132,348.3 | 338,132,348.3 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 81,095,544.5 | 81,095,544.5 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 32,462,213.3 | 32,462,213.3 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | 9,963,932.6 | 9,963,932.6 |
| **7** | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **461,654,038.8** | **461,654,038.8** |
| **8** | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **461,654,038.8** | **461,654,038.8** |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 6,679,116.4 | 6,679,116.4 |
| **10** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **468,333,155.3** | **468,333,155.3** |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -323,681.4 | -323,681.4 |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,385,516.0 | 1,385,516.0 |
| 13 | Тайлант үеийн үр дүн | 32,349,324.9 | 32,349,324.9 |
| **14** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **501,744,314.8** | **501,744,314.8** |

### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,660,401,537.0** | **1,579,790,682.8** | **80,610,854.2** | **95.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,626,506,137.0** | **1,550,334,371.8** | **76,171,765.2** | **95.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **114,918,614.7** | **109,116,870.9** | **5,801,743.8** | **95.0** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 60,821,234.8 | 59,118,585.7 | 1,702,649.1 | 97.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,600,921.1 | 7,352,769.3 | 248,151.8 | 96.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,653,345.9 | 11,040,167.6 | 613,178.3 | 94.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,896,243.2 | 1,884,552.8 | 11,690.4 | 99.4 |
| 2105 | Нормативын зардал | 6,603,142.7 | 6,129,841.8 | 473,300.9 | 92.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,329,609.6 | 1,315,232.2 | 14,377.4 | 98.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 449,670.4 | 427,393.1 | 22,277.3 | 95.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,538,472.3 | 13,138,663.3 | 399,809.0 | 97.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,025,974.7 | 8,709,665.1 | 2,316,309.6 | 79.0 |
| **212** | **ТАТААС** | **605,989,831.5** | **605,989,831.5** | **-** | **100.0** |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 605,989,831.5 | 605,989,831.5 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **905,597,690.8** | **835,227,669.4** | **70,370,021.4** | **92.2** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 91,458,363.0 | 91,405,325.1 | 53,037.9 | 99.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 814,139,327.8 | 743,822,344.3 | 70,316,983.5 | 91.4 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **33,895,400.0** | **29,456,311.0** | **4,439,089.0** | **86.9** |
| 220001 | Барилга байгууламж | 33,437,600.0 | 29,000,756.7 | 4,436,843.3 | 86.7 |
| 221001 | Их засвар | 207,800.0 | 206,579.3 | 1,220.7 | 99.4 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 250,000.0 | 248,975.0 | 1,025.0 | 99.6 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,660,401,537.0** | **1,638,106,984.9** | **22,294,552.1** | **98.7** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,559,176,352.4** | **1,511,336,915.4** | **47,839,437.0** | **96.9** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,559,176,352.4 | 1,511,336,915.4 | 47,839,437.0 | 96.9 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **631,110.0** | **580,912.7** | **50,197.3** | **92.0** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 631,110.0 | 580,912.7 | 50,197.3 | 92.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **100,594,074.6** | **126,189,156.7** | **25,595,082.1** | **125.4** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **122** | **115** | **7** | **94.3** |
| 610001 | Төсвийн байгууллага | 81 | 81 | 0 | 100.0 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 41 | 34 | 7 | 82.9 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **5,454** | **5,351** | **103** | 98.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 206 | 197 | 9.0 | 95.6 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 3,949 | 3,825 | 124.0 | 96.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1,299 | 1,329 | 30.0 | 102.3 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **41,004** | **34,990** | **6,014** | **85.3** |
| **632** | **МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ** | 41,004 | 34,990 | 6,014 | 85.3 |
| 632001 | Төрийн өмчит МСҮТ | 27,263 | 24,701 | 2,562 | 90.6 |
| 632002 | Хувийн МСҮТ | 13,741 | 10,289 | 3,452 | 74.9 |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,331,204.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,233,349.1** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,502,251.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 424,891.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,161.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 67,868.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 713,669.7 |
| 2105 | Нормативын зардал | 390,925.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,119,664.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 487,285.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,256,265.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,988,518.4 |
| | 2 | | Багш, албан хаагчдын улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан жилийн эцэст үр дүнгийн гэрээний урамшуулал олгосон . | 8.4 | | |
| 23 | 1 | Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Зүүн хараа ПТК | Багш, ажилтнуудын ур чадварын нэмэгдлийг тухайн сарын бодогдсон үндсэн цалингаас бус нийт үндсэн цалингаас тооцож 2.0 сая төгрөг илүү олгосон. | 2.0 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | Ц.Эрдэнэчулуун, Б.Энхцэцэг |
| | 2 | | Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээгээр тогтоож цалин илүү олгосон. | 6.6 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | Ц.Эрдэнэчулуун, Б.Энхцэцэг |
| | 3 | | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж авсан албан хаагчдад цалин давхардуулан олгосон. | 0.7 | | |
| 24 | 1 | Төв аймгийн Баянчандмань суман дахь ПТК | Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 3 албан хаагчийн цалингийн хэмжээг Төрийн албаны цалингийн сүлжээний дээд шатлалаар буюу өмнө ажиллаж байсан дээд хэмжээгээр тогтоосны улмаас илүү цалин олгосон. | 1.1 | Захирал, нягтлан бодогч | Э.Амартүвшин, Д.Эрдэнэцэцэг |
| | 2 | | Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ нийлүүлэхээр НТШ-аар шалгарсан "Бүрэн цэнгэл" ХХК-тай Харуул хамгаалалтын ажлын гэрээ байгуулахдаа тендерт ирүүлсэн үнийн саналаас илүү дүнгээр гэрээ байгуулан, төлбөрийг шилжүүлсэн. | 2.3 | | |
| 25 | 1 | Төв аймгийн Заамар суман дахь МСҮТ | Түр сургалтын зардлыг дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас гаргасан. | 2.3 | Захирал, нягтлан бодогч | Б.Нямдорж, Ч.Баярцэцэг |
| | 2 | | Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон тарифыг мөрдөөгүйгээс түлш халаалтын зардлыг илүү төлсөн. | 0.6 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 26 | 1 | Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв | Цалин илүү тооцож олгосон. | 0.2 | Дарга, нягтлан бодогч | Ц.Батдорж, У.Энххүү |
| | 2 | | ГОУХАН төслийн хүрээнд гарсан 21,2 сая төгрөгийн гэрээт ажлын хөлснөөс ажил олгогчид ногдох болон даатгуулагчаас суутгах 5.0 сая төгрөгийн НДШ-г тооцоогүй олгосон. | 5.0 | Дарга, нягтлан бодогч | Ц.Батдорж, У.Энххүү |
| 27 | 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв | Томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, албан томилолтын хуудсыг баталгаажуулаагүй. | 1.3 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | М.Даваабат, С.Баяртулга |
| **НИЙТ ДҮН** | | | | **73.7** | | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН** | | | | | | |
| **V. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН** | | | | | | |
| 28 | 1 | Нийгмийн халамжийн төв сан | 2019 оны 12-р сарын 31-нд Архангай, Булган, Өвөрхангай, Увс аймгийн Халамжийн дэд сангаас төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 276,348,118.62 төгрөгийг төвлөрүүлсэн нь Нийгмийн халамжийн дансанд 2020 оны 1-р сарын 2-нд орж ирснийг санхүүгийн тайланд замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан ба зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй. | 276.3 | ХХҮЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Т.Бадрахбаяр, Д.Билэгмаа |
| | 2 | | Нийгмийн халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлангаар арилжааны банканд 3,024.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 2,119.8 сая төгрөгийн олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн өглөгтэй тайлагнасан бөгөөд 905.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг төвлөрүүлээгүй . Үүний 451.5 сая төгрөг нь 2018 оны тэтгэвэр, тэтгэмжийн олгогдоогүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 32.6 сая төгрөгийн хүүгийн орлого, бусад 420.9 сая төгрөгийн үлдэгдэл нь илүү болон давхар олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн буцаалтын орлогын үлдэгдэл ээлж байна. | 868.8 | | |
| 29 | 1 | Говь-Алтай аймгийн халамжийн сан | Ахмад настны насны хишиг олгох хэмжээг буруу тооцож дутуу олгосон. | 0.2 | Дарга, нягтлан бодогч | М.Мянганбуу, Ц.Эрдэнэцэцэг |
| | 2 | | Жирэмсэн эхийн тэтгэмж авагч иргэнд 0.1 сая төгрөгийг илүү олгосон. | 0.1 | | |
| | 3 | | Тэтгэвэр авагч нас барсан 2 иргэнд 0.3 сая төгрөг дутуу,1 иргэнд 0.2 сая төгрөг илүү олгосон. | 0.5 | | |
| 30 | 1 | Дорнод аймгийн халамжийн сан | Жилийн эцсийн харилцах дансны үлдэгдлийг Нийгмийн халамжийн төв санд төвлөрүүлээгүй. | 3.6 | Дарга, нягтлан бодогч | Н.Мөнхгэрэл, Б.Алтанцэцэг |
| | | **ДҮН** | | **1,149.5** | | |
| **VI. ХӨДӨЛМӨР, ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 31 | 1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | ХЭДС-ийн үйл ажиллагааны зардлаас худалдан авсан гэх ном, гарын авлага сургалтын материалын худалдан авалтууд анхан шатны баримтаар нотлогдоогүй. | 28.9 | Дарга, ерөнхий нягтлан бодогч | Л.Цолмонгэрэл, Г.Нарангэрэл |
| | 2 | | ХЭДС-ийн үйл ажиллагааны зардлаас худалдан авсан шатахууныг байгууллагын нярав хүлээлгэн өгөөгүй. | 1.1 | | |
| 32 | 3 | Баян-Өлгийн аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Нийтийг хамарсан ажил, ахмадын зөвлөх үйлчилгээний хөлснөөс 1.8 сая төгрөгийн татварыг суутган ч татварт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй, хувь хүнээс худалдан авсан бараа, хяналтын урамшуулалд олгосон хөлснөөс 1.0 сая төгрөгийн татварыг суутгаагүй | 2.8 | Дарга, ерөнхий нягтлан бодогч | Б.Сьезхан Т.Фарида |
| 33 | 1 | Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | ХХҮГ-ын дарга нь ХЭДС-ийн зөвлөлийн гишүүнээр ажилласны урамшуулал авсан. | 0.3 | Дарга, ерөнхий нягтлан бодогч | М.Мянганбуу, Л.Удвал |
| | 2 | | Санхүүгийн дэмжлэг олгох гэрээний үнийн дүнгээс илүү дэмжлэг олгосон | 1.0 | | |
| | 3 | | Түрээсийн төлбөр төлсөн анхан шатны баримтгүй байхад 0.3 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлсэн. | 0.3 | | |
| | 4 | | Зээлийн гэрээний эргэн төлөлтийн хугацаа дууссан 13.8 сая зээлийн авлагыг төлүүлэх арга хэмжээ аваагүй. | 13.8 | | |
| 34 | 1 | Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Олон нийтийг хамарсан ажилд зарим иргэн уг ажилд оролцсон эсэх нь тодорхойгүй, харьяаллын бус иргэнийг оролцуулж нийт 0.3 мянган төгрөгийн ажлын хөлсийг олгосон. | 0.3 | Дарга, ерөнхий нягтлан бодогч | М.Отгонтуяа, Т.Оюунгэрэл |
| | | **ДҮН** | | **48.5** | | |
| **НИЙТ ДҮН** | | | | **1,198.0** | | |
| **НИЙТ ТӨЛБӨРИЙН АКТЫН ДҮН** | | | | **1,295.5** | | |

**5.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл.**

| Д/д | № | Харьяа байгууллага | Албан шаардлагын товч утга | Мөнгөн дүн /сая.төг/ | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ** | | | | | | |
| **I. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН** | | | | | | |
| 1 | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн төлбөрт ХНХС-ын эрхлэх асуудлын 3 байгууллагын төсвөөс нийт 46.4 сая төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй. | 63.1 | ХШҮДАГ-ын дарга | Ц.Мөнхзул |
| | 2 | | Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, ХХҮЕГ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 5 байгууллага, 10 дэд сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” , 1 дэд сангийн санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгөгдсөн мөн Булган аймаг дахь МСҮТ, ХАА-н МСҮТ-үүд нь Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа ирүүлээгүйгээс 2019 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна. | 0 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд; ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн; ХШҮДАГ-ын дарга | С.Чинзориг<br>Ц.Эрдэнэтөгс |
| | | **ДҮН** | | **63.1** | | |
| **НИЙТ ДҮН** | | | | **63.1** | | |
| **ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ** | | | | | | |
| II. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН | | | | | | |
| 2 | 1 | | Тус байгууллага нь автомашины хэрэгцээ шаардлага нь бүрэн хангагдсан байхад 2018 оны давсан орлогоос 76.8 сая төгрөгөөр Nissan teana маркийн автомашиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл гараагүй байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн. | 76.8 | ХХҮЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, | Т.Бадрахбаяр, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | Монгол Улсын Засгийн газрын агентлагийн орон тооны орон тооны хязгаар батлах тухай 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар (Засгийн газрын 2018 оны 110, 2019 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчилсөн) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орон тооны хязгаарыг 70 байхаар тогтоосон боловч уг үндсэн орон тооны хязгаарт жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 10 төрийн үйлчилгээний орон тоо батлагдаагүйгээс тэдгээр ажилтнуудын цалин, НДШ-ийн зардлыг 80226- байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний 210801- бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөн Сангийн яамаар хянуулж, төсвийг батлуулж ирсэн бөгөөд 2019 оны гүйцэтгэлээр 93.5 сая төгрөгийн зардлыг дээрх зардлаас санхүүжүүлсэн. | 93.5 | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч, Салбарын төсвийн нэгдсэн төлөвлөлт, мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн | Т.Бадрахбаяр, Б.Оюунбилэг, А.Мандах |
| 3 | 1 | Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Байгууллагын нэмэлт үйл ажиллагааны орлогын 6.0 сая төгрөгийн үлдэгдлийг зарцуулснаар тайлагнаж, 2020 оны 1-р сард хөрөнгө худалдан авсан. | 6.0 | Дарга нягтлан бодогч | Б.СЪЕЗХАН, Мухибат |
| 4 | 1 | Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын үлдэгдэлтэй тайлагнасан. | 5.2 | Дарга нягтлан бодогч | Н.Батжаргал, Баярчимэг |
| 5 | 1 | Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Хоол хүнс, түлш, шатахуун тосолгооны материал, ном хэвлэл хэвлүүлэх зэрэг 4 төрлийн босго үнийн дүнгээс давсан худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэлгүйгээр шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн. | 50.8 | Дарга нягтлан бодогч | М.Мянганбуу, Л.Удвал |
| | 2 | | Төрийн захиргааны дэс түшмэлийн орон тоонд төрийн албан хаагчийн мэргэшлийн сонгон шалгаруулалтад ороогүй 2 хүнийг томилон ТҮ-7 шатлалаар цалинжуулсан. | 18.2 | Дарга нягтлан бодогч | |
| 6 | 1 | Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Төвлөрсөн халаалтад холбогдсон орон сууцанд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон. | 5.3 | Дарга нягтлан бодогч | Г.Хишигдаваа, Буян-Эрдэнэ |
| 7 | 1 | Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас ахмадын сан байгуулж ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1.7 сая төгрөгийг зарцуулсан. | 1.7 | Дарга нягтлан бодогч | Г.Гэрэлбадрах, Ш.Болортуяа |
| 8 | 1 | Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, | Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан. | 0.2 | Дарга нягтлан бодогч | Л.Зоригтбаатар, Идэрээ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2 | халамжийн үйлчилгээний газар | Урсгал засварын зардлаас автомашины засвар үйлчилгээний зардал гаргасан боловч Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэгт бүртгэл хийгээгүй. | 6.5 | | |
| | 3 | | Сарын үйлчилгээний төлбөр нь тодорхой бус, ажил үйлчилгээний гэрээ болон жилийн эцсийн тооцоо нийлсэн актгүйгээр Мандал сумын сувиллын бохир усны төлбөрийг шилжүүлсэн. | 2.3 | | |
| | 4 | | Батлагдсан маршрут, жолоочийн тооцооны хуудасгүйгээр шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан | 2.2 | | |
| 9 | 1 | Төв аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмжийн зардал олгосон. | 1.7 | Дарга нягтлан бодогч | Д.Батцэцэг, Ууганаа |
| | | | Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй өглөгийг тайлант жилийн зардлаас төлсөн. | 0.2 | | |
| 10 | 1 | Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | ХХҮГ-ын даргын суудлын автомашиныг хот дотор ашиглаж 0.7 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан. | 0.7 | Дарга нягтлан бодогч | Б.Эрдэнэхуяг, Эрдэнэцогт |
| 11 | 1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс | Хэлтсийн оффисын түрээсийн гэрээг сонгон шалгаруулалтгүйгээр хийсэн. | 95.0 | Дарга нягтлан бодогч | Л.Цолмонгэрэл, Баттуяа |
| 12 | 1 | Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс | Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа . 2.3 сая төгрөгийн үнэтэй машин биетээр байхгүй байна. | 2.3 | Дарга нягтлан бодогч | М.Отгонтуяа, Ц.Цэвэлсүрэн |
| **НИЙТ ДҮН** | | | | **368.6** | | |
| **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ** | | | | | | |
| **III. ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОР** | | | | | | |
| 13 | 1 | Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор | 2017 онд үүссэн авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй. | 30.3 | Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч | Ш.Одончимэг, Г.Лхагварагчаа |
| **НИЙТ ДҮН** | | | | **30.3** | | |
| **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ** | | | | | | |
| **IV. ХНХС-ЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАР** | | | | | | |
| 14 | 1 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн. | 119.5 | Дарга, ахлах нягтлан бодогч | М.Энх-Амар, У.Батнасан |
| 15 | 1 | Архангай аймаг дахь МСҮТ | Дотуур байрны хүүхдийн хоолны нормыг илүү тооцож олгосон. | 3.8 | Захирал, Нягтлан бодогч | Д.Тунгалаг, Д.Жаргалсайхан |
| | 2 | | Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас багш, ажилчдын хоол болон бусад зардалд зарцуулж хоол, | 8.3 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүнсний зардлыг зориулалт бусаар зарцуулсан. | | | |
| | 3 | | Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагын үлдэгдэлтэй тайлагнасан. | 1.8 | | |
| 16 | 1 | Барилгын ПТК | Дадлагын 150 оюутныг дотуур байранд байрлуулж, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас зарцуулсан. | 9.7 | Нягтлан бодогч | Н.Нарансүрэн |
| 17 | 1 | Баян-Өлгий аймаг дахь МСҮТ | Дотуур байрны хүүхдийн хоолны хүүхдийн нормативыг мөрдөж ажиллаагүйгээс хоолны зардлыг хэтрүүлсэн. | 4.8 | Захирал, нягтлан бодогч | И.Жанболат, Х.Бауыржан |
| 18 | 1 | Говь-Алтай аймаг дахь МСҮТ | Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан. | 4.1 | Захирал, нягтлан бодогч | Г.Гансүх, Ж.Батцэцэг |
| | 2 | | Сургалтын тракторын спидометрийн заалт эвдэрсэн гэх шалтгаанаар ажилласан цагийн тооцоо бүртгэлгүйгээр шатахууны зарцуулалт хийсэн. | 0.7 | | |
| | 3 | | Харьцуулалтын арга хэрэглэлгүйгээр шууд авалт гүйцэтгэсэн | 25.9 | | |
| | 4 | | Хувь хүний нэрийн дансруу бэлнээр шилжүүлсэн мөнгөнөөс ХХОАТ суутган тооцоогүй. | 0.3 | | |
| | 5 | | НДШ-ийн тайланд 0.5 сая төгрөгийн цалингийн гүйцэтгэлийн дутуу тайлагнасан. | 0.5 | | |
| 19 | 1 | Говьсүмбэр аймаг дахь ПТК | Тооцооллын алдаа гаргаснаас халаалтын зардалд өр төлбөр үүсгэсэн. Авлага өмнөх оноос нэмэгдсэн бөгөөд авлага барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй. | 10.0 | Захирал, нягтлан бодогч | Ш.Отгонжаргал, Т.Халиунаа |
| | 2 | | Хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүй байгууллагын эзэмшилд биетээр байхгүй хөрөнгийг бүрэн тоолсон гэж тайлагнасан. | 74.5 | | |
| | 3 | | Богино хугацааны сургалтад зарцуулсан шатахууныг шууд зардлаар тусгасан. Анхан шатны баримт материалын бүрдэл дутуу. | 5.8 | | |
| | 4 | | Нэмэлт санхүүжилтийн дансны орлогоос байгууллагын хэрэгцээнд гэр худалдан авсан боловч бүртгэлд тусгаагүй, шууд зардлаар тайлагнасан. | 2.5 | | |
| 20 | 1 | Дорговь аймаг дахь МСҮТ | Байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан . | 4.7 | Захирал, нягтлан бодогч | Б.Адилбиш, У.Дэлгэрбуян |
| 21 | 1 | Дорнод аймгийн МСҮТ | Худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй | 30.6 | Захирал, нягтлан бодогч | Н.Хүрэлбаатар, Д.Батбаяр |
| | 2 | | Он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй | 0.5 | | |
| | 3 | | Өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан | 2.1 | | |
| 22 | 1 | Дорнод аймгийн ПТК | Худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй | 64.7 | Захирал, нягтлан бодогч | Т.Сүмбэр, Г.Гантуяа |
| | 2 | | Өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан | 9.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | Цалин болон НДШ-ийн зардлын нийт 1,194,628.4 мянган төгрөгийг ажил гүйлгээний утга болон гарсан цаг хугацааг үл хамааран нийлбэр дүнгээр нь журналд бүртгэсэн. | 1,194.6 | | |
| 23 | 1 | Дундговь аймаг дахь МСҮТ | Үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг тооцоогүй. | 37.7 | Захирал, нягтлан бодогч | Ю.Цолмон, Б.Рэнцэн |
| | 2 | | Багаж техник хэрэгсэл зардлаас зориулалт бусаар зарцуулж хөрөнгө худалдан авсан. | 0.2 | | |
| | 3 | | Хоолны хөнгөлөлт олгохдоо татвар буруу суутгасан. | 24.5 | | |
| | 4 | | Насжилт өндөртэй авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах ажил зохион байгуулаагүй. | 11.6 | | |
| | 5 | | Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүй буудлын үйл ажиллагаа эрхлэн олсон орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд тушаагаагүй, бэлнээр зарцуулсан. | 2.9 | | |
| | 6 | | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас зориулалт бусаар багш ажилтнуудын дунд зохион байгуулагдсан гар бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн, газрын кадастрын үнэ, нээлтийн идээний үнэ зэрэгт зарцуулсан. | 2.4 | | |
| 24 | 1 | Монгол Солонгосын ПТК | Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан. | 24.6 | Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч | Х.Цэгмид, П.Пүрэвдорж |
| 25 | 1 | Налайх дүүрэг дэхь МСҮТ | Цалин хөлсний нэмэгдэл, урамшууллыг буруу тооцож олгосон. | 3.1 | Нягтлан бодогч | Г.Ганцэцэг |
| 26 | 1 | Орхон аймаг дахь МСҮТ | Ойн хандив, тусламжийн орлогыг санхүүгийн тайланд огт тайлагнаагүй. | | Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч | Н.Төгсбаатар, Ж.Хүрэлбаатар |
| | 2 | | 2015 онд үүссэн албан томилолт тэтгэмжийн зардлын өглөг нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй ба одоог хүртэл төлж барагдуулаагүй. | 2.0 | | |
| 27 | 1 | Өвөрхангай аймаг дахь МСҮТ | Худалдан авах ажиллагааг хуулийн зохион байгуулж, худалдан авалтыг гүйцэтгээгүй | 45.2 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | С.Санчир, С.Хандсүрэн |
| 28 | 1 | Өмнөговь аймаг дахь МСҮТ | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл: Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн | | Захирал, ерөнхий нягтлан бодогч | А.Түвшинбаяр, Ж.Нандинцэцэг |
| 29 | 1 | Өмнөговь аймаг дахь МСҮТ | Санхүүгийн тайланд 0.2 сая төгрөгийн авлагын, 1.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. | 2.0 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | А.Түвшинбаяр, Ж.Нандинцэцэг |
| 30 | 1 | Сүхбаатар аймаг дахь МСҮТ | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зарим албан хаагчдын орлогыг илүү, болон дутуу | 0.6 | Захирал, нягтлан бодогч | Д.Очирбат, Л.Баасанжав |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | илэрхийлж НДШ төлсөн зөрчил дутагдал | | | |
| 31 | 1 | Сэлэнгэ аймаг дахь МСҮТ | Дээд шатны төсвийн захирагчийн тушаал, шийдвэргүйгээр захиралд улирлын урамшуулал г олгосон. | 0.5 | Захирал, нягтлан бодогч | Д.Очирбат, Л.Баасанжав |
| 32 | 1 | Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Зүүнхараа ПТК | Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардлаас бусад бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллагын зөвшөөрөл аваагүй, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй. | 0.7 | Захирал, ерөнхий нягтлан бодогч | Ц.Эрдэнэчулуун, Б.Энхцэцэг |
| 33 | 1 | Төв аймгийн Баянчандмань суман дахь ПТК | Байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй автомашинд шатахуун талон олгож зарцуулсан. | 6.7 | Захирал, нягтлан бодогч | Э.Амартүвшин, Д.Эрдэнэцэцэг |
| 34 | 1 | Төв аймгийн Эрдэнэ суман дахь ПТК | Байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй автомашинд тушаал шийдвэргүйгээр шатахуун талон олгож зарцуулсан. | 2.6 | Захирал, нягтлан бодогч | Ш.Отгонхүү, Ч.Буянтогтох |
| 35 | 1 | Ховд аймаг дахь Хөгжил ПТК | Өмнөх оноос шилжин ирсэн он дамжсан авлагыг барагдуулаагүй. | 7.5 | Захирал, нягтлан бодогч | Д.Баяраа, Н.Жавзанханд |
| 36 | 1 | Хөвсгөл аймгийн МСҮТ | Зардлын бүлэг хооронд төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан, бараа материалын бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул. | 15.9 | Захирал | Н.Баатар-Очир |
| 37 | 1 | Үйлдвэрлэл урлалын ПТК | Кассаар бэлэн авсан оюутны сургалтын төлбөр, элсэлт, бүртгэлийн хураамж болон бусад орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр ном хэвлэл худалдан авах, биеийн тамир, уралдаан тэмцээний зардал болон урсгал засварын зардалд зарцуулсан | 72.7 | Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ерөнхий нягтлан бодогч | Д.Очирбат, П.Сарантуяа |
| 38 | 1 | Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ,мэдээлэл, арга зүйн төв | 2019 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацааг 5 хоногоор хоцроож ирүүлсэн. | | Дарга, нягтлан бодогч | Ц.Батдорж, У.Энххүү |
| 39 | 1 | Өнөр бүл хүүхдийн төв | Гэрээний дүнгээс илүү дүнгээр худалдан авалтыг гүйцэтгэсэн | 8.7 | Захирал, Нягтлан бодогч | М.Өлзийчимэг, Б.Долзодмаа |
| 40 | 1 | Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв | Шатах тослох материалын тодруулга тайланг алдаатай бэлтгэсэн, эхний болон эцсийн үлдэгдэл зөрүүтэй. | 6.0 | Ерөнхий нягтлан бодогч | Г.Баасансүрэн |
| 41 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар | Бараа материалын тайланд шатахууныг орлого аваагүй, жолоочийн тооцооны хуудсыг хянаж хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүй, материалын тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн. | 1.9 | Ерөнхий нягтлан бодогч | Э.Хаш-Эрдэнэ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 42 | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв. | Эдийн засаг, техник хамтын ажиллагааны тухай МУ-ын ЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын 2016 оны хэлэлцээрийн дагуу " Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих " төслийн хүрээнд Эмчилгээ тоног төхөөрөмжийн 292 зүйл, доторх тавилгын 24 зүйл, гал тогооны тоног төхөөрөмжийн 91 зүйл, эмчилгээ сэргээн заслын тоног төхөөрөмжийн гарын авлага зэрэг нийт 16.9 сая хөрөнгийг 2019 оны 5 сард хүлээн авсан боловч орлого авч санхүүгийн тайланд тусгаагүй байна. Хөрөнгө хүлээн авсан өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцоход 6,514.7 сая төгрөгийн үнийн дүнтэй хөрөнгө хүлээн авсан. | 6,514.7 | Дарга, Ахлах нягтлан бодогч | Р.Галбадрах, Б.Алтансүх |
| | 2 | | Хоол, хүнс худалдан авах гэрээг "Манхан өгөөж" ХХК-тай байгуулж, гүйцэтгэлээр бус батлагдсан төсвийн хэмжээгээр шилжүүлснээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 149.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн. | 149.3 | | |
| 43 | 1 | ХНХЯ | Яамны аппаратын бүтцийн нэгжийн үндсэн орон тоонд багтаагүй төрийн үйлчилгээний 13 орон тооны ажилтнуудын цалин, НДШ-ийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөн Сангийн яамаар хянуулж, төсвийг батлуулж, дээрх зардлаас санхүүжүүлсэн. | 152.5 | ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч | Р.Очбадрах, Л.Сансартуяа |
| | 2 | | Цалингийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулаагүй, дансны өр төлбөрийн тооцоог хянаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ, НДШ-ийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан. | 9.9 | ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч | Р.Очбадрах, Л.Сансартуяа |
| **НИЙТ ДҮН** | | | | **8,684.8** | | |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН** | | | | | | |
| **V. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН** | | | | | | |
| 44 | 1 | Говь-Алтай аймгийн халамжийн сан | Амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшууллын зардлаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийн зардалд гүйлгэн зарцуулсан. | 1.0 | Дарга, нягтлан бодогч | М.Мянганбуу, Ц.Эрдэнэцэцэг |
| | 2 | Сүхбаатар дүүргийн халамжийн сан | Ахмад дайчин болон гавьяат цолтны нэмэгдэл хөнгөлөлтийг 2018-2019 онуудад иргэнд давхардуулан нийт 6.0 сая төгрөгийг олгосон. | 6.0 | Дарга, нягтлан бодогч | М.Оюунтуяа, Б.Баяржаргал |
| | | **ДҮН** | | **7.0** | | |
| **VI. ХӨДӨЛМӨР, ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 45 | 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сан | Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зээл болон Анод банк, Капитал банк, Дэлгэр экспресс ХХК-с авах олон жил болсон, эрсдэлтэй авлагыг барагдуулаагүй . | 19,790.2 | Дарга, нягтлан бодогч | Т.Бадрахбаяр Б.Оюунбилэг |
| 46 | 1 | Баян-Өлгийн аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Сангийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг ХХҮГ-т шилжүүлээгүй, данс бүртгэлд тусгаагүй. | 16.4 | Дарга, нягтлан бодогч | Б.Сьезхан Т.Фарида |
| 47 | 1 | Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 2019 оны санхүүгийн тайлангаар 283 зээлдэгчийн 339.5 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн. | 339.5 | Дарга , нягтлан бодогч | Л.Цолмонгэрэл Г.Нарангэрэл |
| | 2 | | Өмнөх оны аудитаар 842.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйд албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн. | 842.7 | | |
| | 3 | | Аудитад шаардлагатай баримт материал, мэдээллийг шаардсан хугацаанд ирүүлээгүй зөрчилд албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн. | 239.6 | | |
| 48 | 1 | Говь-Алтай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. | Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний дагуу 50.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй дэмжлэгийг бэлэн мөнгөөр үзүүлсэн. | 50.0 | Дарга, нягтлан бодогч | М.Мянганбуу, Л.Удвал |
| | 2 | | Зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлүүлээгүй. | 53.4 | | |
| 49 | 1 | Дархан-Уул аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Он дамжсан авлагын үлдэгдлийг барагдуулаагүй. | 1.2 | Дарга, нягтлан бодогч | С.Энхболд, Б.Гэрэлтзам |
| 50 | 1 | Дундговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Насжилт өндөртэй авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах ажил зохион байгуулаагүй. | 5.0 | Дарга, нягтлан бодогч | Г.Хишигдаваа, Э.Одонтуяа |
| 51 | 1 | Орхон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлийн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй. | 18.9 | Дарга, нягтлан бодогч | Х.Эрдэнэбат, О.Саранчимэг |
| 52 | 1 | Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Хувь хүний орлогын албан татварын өглөгийг дутуу бүртгэсэн. | 2.0 | Дарга, нягтлан бодогч | С.Ундрах, Б.Болд |
| 53 | 1 | Төв аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулаагүй. | 36.5 | Дарга, нягтлан бодогч | Д.Батцэцэг, Д.Цолмон |
| 54 | 1 | Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | Малжуулах арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг, туслалцааны зардлыг илүү зарцуулсан. | 7.5 | Дарга, нягтлан бодогч | Д.Гэрэлбадрах Э.Улаанхүүхэн |
| | 2 | | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгосон санхүүгийн дэмжлэгийн авлагыг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ аваагүй. | 52.1 | Дарга, нягтлан бодогч | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 55 | 1 | Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. | 2017-2018 онд эргэн төлөгдөх нөхцөлөөр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгогдсон санхүүгийн дэмжлэгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй. | 66.2 | Дарга, нягтлан бодогч | Б.Бадамсүрэн, Г.Мөнхцолмон |
| 56 | 1 | Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. | 2015-2018 онд эргэн төлөгдөх нөхцөлөөр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгогдсон санхүүгийн дэмжлэгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй. | 212.1 | Дарга, нягтлан бодогч | Б.Мөнхбаяр, Ц.Ууганжаргал |
| 57 | 1 | Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан. | 2015-2018 онд эргэн төлөгдөх нөхцөлөөр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгогдсон санхүүгийн дэмжлэгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй. | 127.3 | Дарга, нягтлан бодогч | А.Сэрээтэр, Д.Одгэрэл |
| | | **ДҮН** | | **21,860.6** | | |
| **ЗГТС** | | | | **21,867.6** | | |
| **НИЙТ ДҮН** | | | | **31,014.4** | | |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 04 дугаар сарын 24 № 01/226 Улаанбаатар хот

САГ-2020/10-/СТА-ТЕЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн төлбөрт ХНХС-ын эрхлэх асуудлын 3 байгууллагын төсвөөс нийт 63.1 сая төгрөг төлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй байна. Үүнд: *ГБХЗХГ 2 ажилтны 17.5 сая, ХХҮЕГ 1 ажилтны 28.9 сая, Сэлэнгэ аймгийн МСҮТ 1 ажилтны 16.7 сая төгрөг.*

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" заасныг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Акт, албан шаардлагыг биелүүлэх хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтны үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх" гэж заасны дагуу хариуцсан албан тушаалтныг хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\20200424SSA014.Docx

00109083[illegible]

1. Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс төлөгдсөн зардлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төрд учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээг авах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ:**

| **ӨГСӨН:** | **ЗӨВШӨӨРСӨН:** |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ | ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ |
| АУДИТОР С.БАТ-ЭРДЭНЭ | |

*Акт, албан шаардлагын биелэлт хангалтгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\20200424556614.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 04 № 01/227 Улаанбаатар хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Булган аймаг дахь МСҮТ, ХАА-н МСҮТ зэрэг байгууллагууд Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад 2019 оны санхүүгийн тайланг хүргүүлээгүйгээс аудит хийгдээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т " Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "*аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх* ... ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Kheree\Alban Shaardlaga\20200424554G15.Docx

001080837

1. Төсвийн хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланд аудит хийлгээгүй буруутай албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ:**

**ӨГСӨН:**
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР С.БАТ-ЭРДЭНЭ

**ЗӨВШӨӨРСӨН:**
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас гаргасан албан шаардлага, зөвлөмжийг заасан хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Kheree\Alban Shaardlaga\2020\0424SSAG15.Docx